



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/159

Улаанбаатар хот

“Мэдээлэл харилцааны баг байгуулах тухай”

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 5.1.4, 6.1.1, 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Байгууллагын үндсэн болон бусад чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод бэлтгэн хүргэх “Мэдээлэл харилцааны баг”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, тус багийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Мэдээлэл харилцааны багийн ажиллах журмын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мэдээлэл харилцааны баг (Ч.Очирмаа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 010159